

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРААС  
2020 ОНЫ 06 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 06 дугаар сарын 18

Улаанбаатар хот


Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2020 оны 06 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:

Тайлант хугацаанд Монгол Улсад оршин суух үнэмлэх 126 ширхгийг шинээр хэвлэн, 568 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 77 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийн, гадаадын долоон иргэнд регистрийн дугаар олгосон байна. Үйлчилгээний танхимаар 280 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэжээ.

Нийт 681 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 418, 7585-1882 дугаарын утсаар 28, 7013-3459 дугаарын утсаар 30, биечлэн 46, автомат хариулагчаар 159 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Мөн Оросын Холбооны Улсын Улаан-Үд хот дахь консулын газрын ажилтанд гурван удаа, Гадаад харилцааны яамны Консулын газрын ажилтанд нэг удаа, гадаадын нэг иргэнд цахим шуудангаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.



2020 оны 06 дугаар сарын тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 94.5 хувиар, виз олголт 97.5 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 98.5 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 70.6 хувиар, түр ирэгчийн бүртгэл 99.6 хувиар, түр ирэгчийн хасалт 99.0 хувиар, визийн сунгалт 1.7 хувиар тус тус буурсан, харин оршин суух зөвшөөрлийн хасалт 1.9 дахин өссөн байна.

Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан 03 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хөдөлмөр эрхлэгч, хөрөнгө оруулагч гадаадын иргэдийн Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн сунгалтыг цахимаар авч эхэлсэн бөгөөд тайлангийн хугацаанд “Т” ангиллын 11 аж ахуйн нэгж, байгууллагын 11 гадаадын иргэн, “НГ” ангиллын 11 аж ахуйн нэгж, байгууллагын 29 гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгалаа. Мөн 05 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн түр ирэгч гадаадын иргэдийн визийн сунгалтын хүсэлтийг цахимаар хүлээн авч эхэлсэн бөгөөд тайлангийн хугацаанд гадаадын нэг иргэний хүсэлтийг шийдвэрлэсэн.


Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай Засгийн газар, Улсын онцгой комиссын холбогдох тогтоол, шийдвэртэй холбогдуулан Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл олголт, Монгол Улсад түр ирэгч болон албан, хувийн хэргээр оршин суух гадаадын иргэний тус байгууллагаас авах үйлчилгээний тоо буурсан үзүүлэлттэй байна.

Иргэний харьяалал, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэг удаагийн зарлигаар гурван иргэн гадаадын нэг улсын харьяат болохоор Монгол Улсын харьяатаас гарсан байна. Дээрх иргэдийн мэдээлэл болон Ерөнхийлөгчийн зарлигийг Гадаад харилцааны яамны Консулын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яаманд хүргэх ажлыг зохион байгууллаа.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан харьяалалгүй нэг хүний хүсэлтийг хүлээн авсан ба холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийж байна.

Хоёрдмол харьяалал үүсгэсэн 11 иргэнийг шинээр бүртгэж мэдээллийн санд оруулсан ба 2020 оны 06 дугаар сарын байдлаар тус байгууллагын мэдээллийн санд хоёрдмол харьяалал үүсгэсэн 3667 иргэн бүртгэлтэй байна.




Тайлант хугацаанд салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан хоёр олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтийг хүлээн авсан. 2020 оны 06 дугаар сарын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 90 төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар байна.

#### 1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлант хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн гадаадын нэг иргэнийг байгууллагын даргын нэг удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн хоёр удаагийн захирамжаар гадаадын нэг улсын хоёр иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн байранд саатуулсан.

Тайлант хугацаанд хоёр удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, гадаадын дөрвөн иргэнийг хамруулсан. Түүнчлэн есөн гадаадын иргэн, 16 аж ахуйн нэгж, байгууллага /гадаадын 19 иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 13,130,000 /арван гурван сая нэг зуун гучин мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.



2020 оны 06 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 90.0 хувиар, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 76.1 хувиар, албадан гаргагдсан гадаадын иргэн 93.3 хувиар тус тус буурсан байна.

### ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажил, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

Байгууллагын үйл ажиллагаанд холбогдох 18 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны

хөтөлбөрийн таван заалт, Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн гурван заалтын хэрэгжилтийг нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгүүлснээр Даргын дэргэдэх зөвлөлийн 2020 оны 09 дүгээр хурлаар хэлэлцүүлэн хэрэгжилтийг хурлын тэмдэглэлийн хамт, “Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2020 оны эхний хагас жилд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл, Засгийн газрын 2018 оны 01 дүгээр “Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай” албан даалгаврыг 2018-2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 2020 оны эхний хагас жилийн хэрэгжилт, Улсын онцгой комиссын есдүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх “Амны хаалтаа зүүцгээе” аяны мөрөөр төв болон орон нутаг дахь газруудад хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, байгууллагын 2020 оны 05 дугаар сарын үйл ажиллагааны тоон мэдээг инфографик хэлбэрээр гарган тус тус албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.

Зорчигчийн урьдчилсан мэдээллийн дэвшилтэд систем (APP)-ийг Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудалд нэвтрүүлэх тухай Засгийн газрын 2018 оны 306 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх танилцуулгыг Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх нэгдсэн төлөвлөгөөний гишүүн байгууллагуудын хамтарсан долоодугаар хуралд танилцуулсан.

Засгийн газрын 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл олгох тухай” журамд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан цэргийн сургуулийн сонсогчоор суралцаж байсан хугацаа болон цэргийн хугацаат албыг биеэр хаасан албан хаагчдын судалгааг гаргаж, байгууллагын даргын 2020 оны Б/151 дүгээр тушаалаар 18 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгож эхлэв. Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/82 дугаар тушаалаар төрийн захиргааны хоёр албан хаагчид зэрэг дэвийг шинээр, зургаан албан хаагчид зэрэг дэвийг ахиулан шинэчлэн олголоо.

Байгууллагын 2020 оны сургалтын төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны эрх олгох /АЗ/ хоёрдугаар ээлжийн сургалтыг “Худалдан авах ажиллагааны хөтөч” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, 14 албан хаагч хамрагдав.

Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлээр найман мэдээ, мэдээлэл, ярилцлагыг байгууллагын цахим хуудас болон байгууллагын цахим сүлжээгээр олон нийтэд мэдээлэв. Тухайлбал, “20 жилийн ойд зориулсан гэрэл зургийн цомог хэвлэгдлээ” мэдээ “montsame.mn”, “ontslokh.mn”, “mnb.mn” цахим хуудаст, “Элчин сайд Жалгас Жумаевич Адилбаевыг хүлээн авч уулзлаа” мэдээ “newswall.mn”, “tur.mn” цахим хуудаст тус тус нийтлэгдсэн. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон байгууллагын хэмжээнд хийгдсэн томоохон ажлуудыг танилцуулсан байгууллагын даргын ярилцлага өдөр тутмын “Үндэсний шуудан” сонинд “Д.Мөрөн: Коронавирусийн үед гадаадын иргэд эх орон руугаа буцах хүсэлгүй байна” гарчигтайгаар нийтлэгдлээ. Ярилцлагыг өдөр тутмын мэдээллийн

“gogo.mn”, “zaluucom.mn”, “news.mn”, “ikon.mn”, “ontslokh.mn”, “zarig.mn”, “arслан.mn”, “24tsag.mn” цахим хуудсуудад нийтлүүлсэн.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 58 өргөдөл, хоёр гомдол ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 48 өргөдөл, нэг гомдол шийдвэрлэгдэж, 10 өргөдөл, нэг гомдол шийдвэрлэлтийн шатандаа байна. Нийт өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.

Байгууллагаар үйлчлүүлсэн болон нэвтэрсэн иргэдийг бүртгэж, халууныг хэмжин шаардлагатай тохиолдолд асуумж авч, зөвлөгөө өгөн ажиллаж 06 дугаар сард 796 иргэн, нийт хугацаанд 5624 иргэд нэвтэрч бүртгүүлснээс биеийн дундаж температур 36.4°C байв.

## 2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн эрх олгох журмыг байгууллагын даргын 2020 оны А/132 дугаар тушаалаар шинэчлэн баталлаа.

Тайлант хугацаанд хоёр албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлсэн.

Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд танилцуулах, авлигаас ангид байхыг уриалах зорилгоор “Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтны давхар эрхэлж болох ажил” сэдвээр мэдээлэл бэлтгэн олон нийтийн сүлжээгээр хүргэв.

Байгууллагын дарга тэргүүтэй төлөөлөгчид Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин Сайд Ноён Жалгас Жумаевич Адилбаевийг хүлээн авч уулзан, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцож, Монгол Улсад байгаа Бүгд Найрамдах Казахстан Улсын иргэдийн виз, оршин суух зөвшөөрлийн талаар мэдээлэл солилцлоо.

## 2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

“evisa.mn” системийн тайлан гаргах модулийг илүү боловсронгуй болгох хөгжүүлэлтийг хийснээр тайланг мэргэжилтэн, визийн хүсэлт, визийн хүсэлтийн төлөв тус бүрээр, мөн хугацааны хязгаараар гаргах боломжтой болгов. Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэлтийн программ хангамжийг ажиллагаанд оруулж, холбогдох сургалтыг зохион байгууллаа. Мөн цахим архивийн программ хангамжийн холбогдох хөгжүүлэлтийг хийлээ.

Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд “evisa.mn” системийг зөвхөн Монгол Улсаас хандах боломжтой болгож, бүх гадаад хаягт хязгаарлалт хийн, ажлын тайланг албан бичгээр хүргүүлсэн.

## 2.4. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2020 онд 7.7 тэрбум төгрөг батлагдсан. 06 дугаар сард 3 тэрбум 995.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 2 тэрбум 825.7 сая төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу энэ

оны 06 дугаар сарын байдлаар 662.5 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 283.3 сая төгрөгийн хүү торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэн ажиллалаа.

Төрийн худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн албан бичигт дурдсан байнгын хэрэгцээт бараа, үйлчилгээний зах зээлийн болон эрэлт нийлүүлэлтийн судалгааг хийхтэй холбоотойгоор байгууллагын төв болон орон нутаг дахь газрын 2016-2019 оны худалдан авалтыг эдийн засгийн ангилал тус бүрээр нэгтгэн дэлгэрэнгүй судалгааг бэлтгэсэн.

#### 2.5. Хяналт шинжилгээ, аудитын чиглэлээр:

Байгууллагын 2020 оны 05 дугаар сарын үндсэн үйл ажиллагааны мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын Ажлын албанд, Гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын 2020 оны 05 дугаар сарын статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус албан бичгээр хүргүүлсэн.

Байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу Дорноговь аймаг дахь газрын 2019 он, 2020 оны нэгдүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын шалгалтыг эхлүүлээ. Мөн Сэлэнгэ аймаг дахь Хойд бүс дэх газрын 2019 он, 2020 оны нэгдүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын мөрөөр илэрсэн зөрчлийг арилгах тухай зөвлөмж, хугацаатай үүрэг өгч ажиллалаа.

#### 2.6. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

“Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах, журам батлах тухай” Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 188 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын мөн оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 22 дугаар хурлын тэмдэглэлийн хэрэгжилтийг тус тус ханган ажиллах үүргийг албан бичгээр орон нутаг дахь газруудад хүргүүлэн, хяналт тавин ажиллаж байна.

Ховд аймаг дахь Баруун бүс дэх газар “Цахим нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулж байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагааны талаар олон нийтэд сурталчлав. Цахим хэлбэрээр хийсэн тус өдөрлөгт 2000 орчим иргэн хандалт хийж, 45 иргэн асуулт асууж холбогдсон.

Дорнод аймаг дахь Зүүн бүс дэх газар Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран “Стрессийн үр дагавар” сэдвээр хамтарсан сургалт, Дорноговь аймаг дахь газар Замын-Үүд сумын сум дундын Цагдаагийн хэлтэс, Хилийн мэргэжлийн хяналтын албатай хамтран “Зам тээврийн осол шалтгаан, нөхцөл, Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм”, “Хамгаалах хувцас, хэрэгсэл хэрэглэх заавар” сэдвүүдээр цахим сургалт, Ховд аймаг дахь Баруун бүс дэх газар Ховд аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газартай хамтран “Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай” хуулиудад орсон нэмэлт өөрчлөлт, “Мэдээллийн аюулгүй байдал, түүний төрөл, урьдчилан сэргийлэх”, “Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” сэдвүүдээр тус тус сургалт зохион байгуулав.